



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага боловсролын Бэлтгэл хөтөлбөрийг нэгдүгээр, Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, Математикийн сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, Яриа бичгийн сургалтын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Биет зүйлийн сургалтын хөтөлбөрийг тавдугаар, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн захирал /Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай сургуулийн Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



ЦӨГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын,
сайдын 2018 оны 08 сарын 08 өдрийн А/1492
тоот тушаалын 10 хэсгээр

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 29
ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛ
“АЙЗАМТ ХӨДӨЛГӨӨНТ ДАСГАЛ” ХӨТӨЛБӨР

НЭГ. ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Сонсголын алдагдал нь танин мэдэхүй, хувь хүний хөгжлийг сааруулаад зогсохгүй тэнцвэрийн төвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг тул сонсголын бэрхшээлтэй хүүхдэд дотоод сонсгол, мэдрэмжээ хөгжүүлэх, хөдөлгөөний эвсэлтэй болох, илэрхийллийн арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зайлшгүй хэрэгцээ үүсч байна.

Эдгээрийг сурагч хөдөлгөөнд суурилсан хичээл, үйл ажиллагааны явцад л ухамсартайгаар сурах боломжтой юм. Энэ нь конструктивизмийн “Мэдлэг нэг хүнээс нөгөөд юүлэгддэггүй, харин хүн бүр мэдлэгийг өөрөө бүтээдэг” гэсэн үзэл санаатай нийцэж байгаа юм. Тэгэхлээр бид энэхүү үзэл онолд тулгуурлан сурагчид сурах арга барилыг эзэмших, мэдлэгийг өөрөө бүтээх, идэвхтэй үйл ажиллагааг бий болгох хэрэгтэй болно.

Иймд “Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээл сурагчдын дараах чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Тухайлбал:

- Бусадтай нээлттэй харилцах
- Урлаг, соёлыг ойлгон хүндэтгэлтэй хандах
- Хичээлээр эзэмшсэн ойлголт, мэдлэгээ хэрэглэх
- Санаа бодлоо илэрхийлэх, эв нэгдэлтэй хамтран ажиллах

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Зорилго

Сурагч нь бие бялдар, авьяас, гоо сайхны мэдрэмжээ хөгжүүлэх явцдаа аман болон дохионы хэлний чадвараа дээшлүүлж, түүнийгээ бүтээлчээр илэрхийлэх арга барилд суралцан амьдрах ухааны зөв дадал хэвшилтэй иргэн болж төлөвшинө.

2.2. Зорилт

- Хичээл, урлаг соёлын үйл ажиллагаагаар дамжуулан урлагийн хэл, нэр томъёог ойлгох
- Гүйцэтгэлийн чадвараа хөгжүүлэх явцдаа урлаг, гоо зүйн мэдрэмжээ багшийн дэмжлэгтэй болон бие даан илэрхийлэх
- Айзамт дасгал, хөдөлгөөний ач холбогдол, үр дүнг мэдэрч, эрүүл мэндээ хамгаалах аргад сурах, хэрэглээ болгох
- Үндэсний болон хүн төрөлхтний урлагийн баялаг өв сан, үнэт зүйлсийг хүндэтгэн бахархах